

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ОРА-2025/047/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Эрдэнэт хот 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва Утас: 70353088 Цахим хаяг: purevlhagvar@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Ахлах аудитор: О.Гантуяа Утас: 70350757 Цахим хаяг: gantuyao @audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.25 № 77

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ А.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны тодотгосон төсөв батлах 01 дүгээр тогтоолоор үндсэн үйл ажиллагааны зардлыг 2,863,719.7 мянган төгрөг, багийн ажлын албаны зардлыг 316,346.3 мянган төгрөг, сумын орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг 6,534,612.5 мянган төгрөгөөр тус тус баталж зардлын ангиллын дагуу зарцуулж хэмнэлтийг бүрэн төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 3.6 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

### Аудитын гол асуудал

Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоолын 4-т “Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16” гэж заасныг хэтрүүлэн Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь 54 орон тоотойгоор ажиллаж байна.

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны тодотгосон төсөв батлах 01 дүгээр тогтоолоор үндсэн үйл ажиллагааны зардлыг 2,863,719.7 мянган төгрөг, багийн ажлын албаны зардлыг 316,346.3 мянган төгрөг, сумын орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг 6,534,612.5 мянган төгрөгөөр тус тус баталж зардлын ангиллын дагуу зарцуулж хэмнэлтийг бүрэн төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 3.6 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

#### **Бусад асуудал**

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 57 зорилт, 121 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг 91.5 хувьтай үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,013,954,945.82</u></b>	<b><u>846,375,838.82</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	580.00	
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	580.00	
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	580.00	
31213	Арилжааны банк дахь харилцах	580.00	
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	0.00	
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	13,585,696.49	
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	13,585,696.49	
3351	Байгууллагаас авах авлага	13,585,696.49	3.642.49
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	950,808,669.33	
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	527,178,169.33	
35110	Тусгай зориулалттай материал	527,178,169.33	404,201,696.33
35600	Мал амьтад	423,630,500.00	355,470,500.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	49,560,000.00	
36300	Тэжээлийн нөөц	49,560,000.00	86,700,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>7,554,019,618.89</u></b>	<b><u>19,388,262,421.86</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	7,554,019,618.89	19,388,262,421.86
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	7,508,000,618.89	<b><u>19,065,171,214.66</u></b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,748,473,444.25	14,750,607,638.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	-2,275,505,520.75
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,235,744,864.00	1,945,314,995.77
39204	Хуримтлагдсан элэгдэл	-528,063,819.28	-729,877,852.59
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,165,576,451.41	1,470,441,716.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	-712,925,310.80	-871,718,094.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	699,800,099.61	817,260,099.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	-355,752,185.46	-442,772,281.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,806,273,975.52	6,376,978,278.52
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	-1,884,520,843.85
39216	Дуусаагүй барилга, байгууламж	10,000,000.00	10,000,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b><u>46,019,000.00</u></b>	<b><u>323,091,207.20</u></b>
39301	Програм хангамж	3,564,000.00	3,564,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,189,000.00	-3,264,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	45,644,000.00	322,791,207.20
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>8,567,974,564.71</u></b>	<b><u>20,335,675,181.86</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>6,400,000.00</u></b>	<b><u>307,211,313.22</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	6,400,000.00	<b><u>307,211,313.22</u></b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	6,400,000.00	<b><u>307,211,313.22</u></b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	6,400,000.00	<b><u>307,211,313.22</u></b>
41361	Байгууллагад төлөх өглөг	6,400,000.00	307,211,313.22
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>8,561,574,564.71</u></b>	<b><u>20,083,683,868.64</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	8,561,574,564.71	20,083,683,868.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	704,130,855.63	704,130,855.63
51101	Өмч: - төрийн	704,130,855.63	704,130,855.63
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	6,660,010,158.92	<b><u>18,182,119,462.85</u></b>
51210	Өмнөх үеийн үр дүн	4,857,151,446.87	8,512,754,564.71

51220	Тайлант үеийн үр дүн	1,802,858,712.05	9,614,144,898.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,197,433,550.16	1,197,433,550.16
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>8,567,974,564.71</u></b>	<b><u>20,335,675,181.86</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>10,122,350,947.78</b>	<b>21,084,361,700.23</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,312,125,427.78</b>	<b>11,158,738,756.74</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,312,125,427.78</b>	<b>11,158,738,756.74</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,100,816.00	7,860,288.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,100,816.00	7,860,288.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,576,934,340.78	9,010,723,453.74
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	728,090,271.00	2,140,155,015.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>6,810,225,520.00</b>	<b>218,804,731.49</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>123,432,820.00</b>	<b>218,804,731.49</b>
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,854,820.00	216,812,831.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,578,000.00	1,922,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>6,686,792,700.00</b>	<b>9,706,818,212.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	6,686,792,700.00	9,706,818,212.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	0.00	0.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,615,967,926.06</b>	<b>7,209,039,674.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,615,967,926.06</b>	<b>7,209,039,674.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,639,793,785.36</b>	<b>7,209,039,674.89</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>911,836,915.18</b>	<b>1,385,511,806.61</b>
210101	Үндсэн цалин	545,841,969.41	555,694,608.99
210102	Нэмэгдэл	287,860,197.25	666,318,075.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,531,948.58	30,286,141.62
210104	Урамшуулал	49,340,292.22	123,581,130.08
210105	Гэрээт ажлын хөлс	1,262,507.72	9,631,850.41
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>112,262,834.34</b>	<b>168,031,611.13</b>
210201	Тэтгэврийн даатгал	77,893,459.59	111,807,232.05
210202	Тэтгэмжийн даатгал	9,182,471.84	14,192,768.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,266,975.40	10,191,504.48
210204	Ажилгүйдлийн даатгал	1,756,443.56	3,523,521.28
210205	Эрүүл мэндийн даатгал	16,163,483.95	28,316,585.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>159,439,436.10</b>	<b>243,464,275.26</b>
210301	Гэрэл, цахилгаан	42,919,033.75	52,099,517.43
210302	Түлш, халаалт	110,666,300.00	184,973,720.00
210303	Цэвэр, бохир ус	5,854,102.35	6,391,037.8
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>193,672,099.02</b>	<b>258,357,918.23</b>
210401	Бичиг хэрэг	22,639,300.00	30,842,500.00
210402	Тээвэр, шатахуун	94,507,995.36	146,684,054.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,716,456.00	7,671,904.20

210404	Ном, хэвлэл	500,000.00	2,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	51,908,000.00	21,908,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,400,347.66	48,751,560.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>3,534,000.00</b>	<b>4,297,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,534,000.00	4,297,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>354,181,647.00</b>	<b>545,096,100.00</b>
210601	Багаж, техник хэрэгсэл		8,653,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,100,000.00	00
210604	Урсгал засвар	346,081,647.00	536,443,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,230,800.00</b>	<b>3,800,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,230,800.00	3,800,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>189,637,727.50</b>	<b>327,581,477.50</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	174,611,602.00	244,821,136.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,498,039.00	2,058,151.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	627,496.50	1,263,042.50
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	240,000.00	562,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,500,000.00	57,900,000.00
210807	Газрын төлбөр	460,590.00	790,348.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,700,000.00	20,186,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,711,998,326.22</b>	<b>1,760,882,524.94</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	763,732,724.67	693,879,901.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,092,300.00	12,750,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	936,173,301.55	1,054,252,623.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>976,174,140.70</b>	<b>2,512,016,961.22</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>50,786,950.00</b>	<b>186,268,196.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,503,300.00	78,163,176.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан ажилтны тэтгэмж		87,944,440.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,283,650.00	20,160,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	925,387,190.70	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	925,387,190.70	2,325,752,987.71
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>5,506,383,021.72</b>	<b>13,875,322,025.34</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	3,703,524,309.67	4,261,177,127.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	20,350,000.00	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-3,703,524,309.67	-4,261,177,127.20
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,802,858,712.05</b>	<b>9,614,144,898.14</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>6,851,596,543.48</b>	<b>9,933,483,231.49</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,100,816.00</b>	<b>7,860,288.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,100,816.00	
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	7,100,816.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,100,816.00	7,860,288.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>6,844,495,727.48</b>	<b>218,804,731.49</b>

<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	143,379,604.64	218,804,731.49
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,854,820.00	216,812,731.49
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,524,784.64	1,992,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>6,686,792,700.00</b>	<b>9,706,818,212.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	6,686,792,700.00	9,706,818,212.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	0.00	
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>14,323,422.84</b>	<b>89,038,909,33</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	14,323,422.84	89,038,909,33
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>3,041,482,257.48</u></b>	<b><u>6,051,365,073.62</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>3,041,482,257.48</u></b>	<b><u>6,051,365,073.62</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>2,032,833,997.45</u></b>	<b><u>3450,304,980.58</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	911,836,915.18	1,385,511,806.61
210101	Үндсэн цалин	542,661,063.54	555,694,608.99
210102	Нэмэгдэл	287,860,197.25	666,318,075,.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,531,948.58	30,286,141.62
210104	Урамшуулал	52,528,698.09	123,581,130.08
210105	Гэрээт ажлын хөлс	1,255,007.72	9,631,850.41
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>112,262,834.34</b>	<b>168,031,611.13</b>
210201	Тэтгэврийн даатгал	77,893,459.59	111,807,232.05
210202	Тэтгэмжийн даатгал	9,182,471.84	14,192,768.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,266,975.40	10,191,504.48
210204	Ажилгүйдлийн даатгал	1,756,443.56	3,523,521.28
210205	Эрүүл мэндийн даатгал	16,163,483.95	28,316,585.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>159,439,436.10</b>	<b>239,700,557.11</b>
210301	Гэрэл, цахилгаан	42,919,033.75	48,335,799.28
210302	Түлш, халаалт	110,666,300.00	184,973,720.00
210303	Цэвэр, бохир ус	5,854,102.35	6,391,037.83
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>199,888,337.33</b>	<b>258,358,018.23</b>
210401	Бичиг хэрэг	22,639,300.00	30,842,500.00
210402	Тээвэр, шатахуун	101,992,780.00	146,684,054.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,716,456.00	7,671,904.23
210404	Ном, хэвлэл	500,000.00	2,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	51,908,000.00	21,908,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,131,801.33	48,751,560.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>9,940,000.00</b>	<b>25,900,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,940,000.00	25,900,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>404,305,647.00</b>	<b>617,943,095.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,124,000.00	65,999,995.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,100,000.00	15,500,000.00
210604	Урсгал засвар	346,081,647.00	536,443,100.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>3,230,800.00</b>	<b>3,800,000.00</b>
210702	Дотоод албан томилот	3,230,800.00	3,800,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>189,637,647.50</b>	<b>698,090,492.50</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	174,611,522.00	615,330,151.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,498,039.00	2,058,151.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	627,496.50	1,263,042.50
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	240,000.00	562,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,500,000.00	57,900,000.00
210807	Газрын төлбөр	460,590.00	790,348.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,700,000.00	20,186,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,292,380.00</b>	<b>52,696,400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,200,080.00	40,219,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,092,300.00	12,750,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,008,648,260.03</b>	<b>2,601,060,093.04</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>69,675,372.84</b>	<b>2,601,060,093.04</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	14,323,422.84	89,038,909.33
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,503,300.00	78,163,176.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		87,944,440.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,848,650.00	20,160,580.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>938,972,887.19</b>	<b>2,325,752,987.22</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	925,387,190.70	2,325,749,345.22
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	13,585,696.49	3,642.49
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>3,810,114,286.00</u></b>	<b><u>3,971,157,067.20</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,810,568,856.00</b>	<b>3,971,157,647.20</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,810,568,856.00</b>	<b>3,971,157,647.20</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,810,568,856.00</b>	
220001	Барилга байгууламж	2,594,238,646.00	
223001	Бусад хөрөнгө	1,129,349,210.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	86,981,000.00	3,971,157,647.20
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>3,810,568,856.00</u></b>	<b><u>3,971,157,647.20</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-454,570.00</b>	<b>-580.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>455,150.00</b>	<b>580.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>580.00</b>	

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	704,130,855.63	1,197,433,550.16	4,857,151,446.87	6,758,715,852.66
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	704,130,855.63	1,197,433,550.16	4,857,151,446.87	6,758,715,852.66
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,802,858,712.05	1,802,858,712.05
C08	2023 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	704,130,855.63	1,197,433,550.16	6,660,010,158.92	8,561,574,564.71

D01	<b>2024 оны 1-р сарын 1-ээр үлдэгдэл</b>	<b>704,130,855.63</b>	<b>1,197,433,550.16</b>	<b>6,660,010,158.92</b>	<b>8,561,574,654.71</b>
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			<b>1,852,744,405.79</b>	<b>1,852,744,405.79</b>
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>704,130,855.63</b>	<b>1,197,433,550.16</b>	<b>8,512,754,564.71</b>	<b>10,414,318,970.50</b>
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	9,614,144,898.14	9,614,144,898.14
D09	<b>2024 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>704,130,855.63</b>	<b>1,197,433,550.16</b>	<b>18,126,899,462.85</b>	<b>20,028,463,868.64</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,713,918,212.00</b>	<b>7,388,929,214.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,179,305,612.00</b>	<b>3,127,752,087.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,995,760,912.00</b>	<b>2,944,399,411.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,392,322,100.00</b>	<b>1,357,342,006.61</b>
210101	Үндсэн цалин	600,830,500.00	530,876,540.69
210102	Нэмэгдэл	719,263,600.00	663,944,343.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,428,000.00	29,308,141.62
210104	Урамшуулал		123,581,130.08
210105	Гэрээт ажлын хөлс	28,800,000.00	9,631,850.41
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>176,531,200.00</b>	<b>164,172,771.13</b>
210201	Тэтгэврийн даатгал	120,838,200.00	109,183,200.05
210202	Тэтгэмжийн даатгал	13,923,400.00	13,883,966.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,525,100.00	10,037,103.48
210204	Ажилгүйдлийн даатгал	3,398,200.00	3,369,120.28
210205	Эрүүл мэндийн даатгал	27,846,300.00	27,699,381.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>242,458,500.00</b>	<b>239,700,557.11</b>
210301	Гэрэл, цахилгаан	48,335,800.00	48,335,799.28
210302	Түлш, халаалт	184,982,100.00	184,973,720.00
210303	Цэвэр, бохир ус	9,140,600.00	6,391,037.83
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>168,603,300.00</b>	<b>168,575,204.23</b>
210401	Бичиг хэрэг	27,587,500.00	27,587,500.00
210402	Тээвэр, шатахуун	61,600,000.00	61,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,700,000.00	7,671,904.23
210404	Ном, хэвлэл	2,500,000.00	2,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21,908,000.00	21,908,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,307,800.00	47,307,800.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>25,900,000.00</b>	<b>25,900,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,900,000.00	25,900,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>604,358,000.00</b>	<b>604,357,995.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	66,000,000.00	65,999,995.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,500,000.00	15,500,000.00
210604	Урсгал засвар	522,858,000.00	522,858,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,500,000.00</b>	<b>3,800,000.00</b>

210702	Дотоод албан томилолт	4,500,000.00	3,800,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>328,118,412.00</b>	<b>327,581,477.50</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	244,161,412.00	244,821,136.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	2,058,200.00	2,058,151.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,300,000.00	1,263,042.50
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	562,500.00	562,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	57,900,000.00	57,900,000.00
210807	Газрын төлбөр	1,000,000.00	790,348.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	21,136,300.00	20,186,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>52,969,400.00</b>	<b>52,969,400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,219,400.00	40,219,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,750,000.00	12,750,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>183,544,700.00</b>	<b>183,352,676.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>183,544,700.00</b>	<b>183,352,676.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	78,355,200.00	78,163,176.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	87,944,500.00	87,944,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,245,000.00	17,245,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,534,612,600.00</b>	<b>4,261,177,127.20</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,534,612,600.00</b>	<b>4,261,177,127.20</b>
220001	Барилга байгууламж	1,798,871,100.00	1,434,914,895.00
223001	Бусад хөрөнгө	3,924,576,200.00	2,536,242,752.20
	Нийгмийн бүлэгт чиглэсэн	811,165,300.00	290,019,480.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>9,713,918,212.00</b>	<b>9,714,678,500.00</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>9,706,818,212.00</b>	<b>9,706,818,212.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	9,706,818,212.00	9,706,818,212.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>7,100,000.00</b>	<b>7,860,288.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,100,000.00	7,860,288.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>580.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	580.00	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>55</b>	<b>55</b>
620001	Удирдах ажилтан	3	3
620002	Гүйцэтгэх ажилтан	27	27
620003	Үйлчлэх ажилтан	22	22
620004	Гэрээт ажилтан	3	3
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>55</b>	<b>55</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	19	19
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	28	28
650010	Гэрээт ажилтан	3	3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>143,379,604.64</b>	<b>218,814,731.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>143,379,604.64</b>	<b>218,814,731.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	114,630,408.15	218,814,731.49
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>21,337,505.66</b>	<b>28,169,800.00</b>
210101	Үндсэн цалин	15,107,942.12	24,818,068.30
210102	Нэмэгдэл	5,765,563.54	2,373,731.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	464,000.00	978,000
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,554,088.52</b>	<b>3,858,840.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,736,780.19	2,624,032.00
210202	Тэтгэмжийн даатгал	204,327.10	308,802.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	163,461.65	154,401.00
210204	Ажилгүйдлийн даатгал	40,865.42	154,401.00
210205	Эрүүл мэндийн даатгал	408,654.16	617,204.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	0.00	
210301	Гэрэл, цахилгаан	0.00	
210302	Түлш, халаалт	0.00	
210303	Цэвэр, бохир ус	0.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>44,701,473.97</b>	<b>89,782,814.00</b>
210401	Бичиг хэрэг	2,037,000.00	3,255,000
210402	Тээвэр, шатахуун	40,592,780.00	85,084,054
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,619,943.97	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	451,750.00	1,443,760.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	540,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	540,000.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>31,185,650.00</b>	<b>13,585,100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	
210602	Тавилга	0.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	600,000.00	
210604	Урсгал засвар	30,585,650.00	13,585,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,311,690.00</b>	<b>80,489,535.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,311,690.00	80,489,535.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	15,163,500.00	
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	15,163,500.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,163,500.00	2,915,000
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>13,585,696.49</b>	<b>3,642.49</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	13,585,696.49	3,642,49
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>143,379,604.64</b>	<b>218,804,731.49</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>143,379,604.64</b>	<b>218,804,731.49</b>
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,854,820.00	216,812,731.49

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,524,784.64	1,992,000.00

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 551,336.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 551,336.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилтийг 760.3 мянган төгрөгөөр илүү, төсөвт байгууллагын өөрийн орлогын гүйцэтгэлийг 760.3 мянган төгрөгөөр дутуу тусгасан, үндсэн хөрөнгийн элэгдлийг 549,815.4 сая төгрөгөөр илүү илэрхийлснийг бууруулж санхүүгийн тайланг залруулав.

Аудитаар нийт 60,357.9 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 58,732.9 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 1,625.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 5.2 Албан шаардлага

Жаргалант сумын Засаг даргын үр дүнгийн урамшуулал 1,950.0 мянган төгрөгийг жилийн эцсийн тайландаа өглөгөөр бүртгээгүй, төсвийн жил дамнуулан олгосон, байгууллагын бүтцэд батлагдаагүй орон тоонд 7,091.4 мянган төгрөгийн ажил хавсарсны нэмэгдэл цалин олгосон, улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 48,489.0 мянган төгрөг олгосон, улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх зардлаас 1,202.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн зөрчлүүдэд 4 албан шаардлага хүргүүлсэн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Зардлын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Багийн Засаг даргын нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 16 иргэнд 1,005.0 мянган төгрөгийн тэтгэмж дэмжлэг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 58.1.11-д "иргэнийг шагнаж урамшуулах, иргэнд дэмжлэг, тусламж үзүүлэх тухай саналыг сумын Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Иргэнийг шагнаж урамшуулах, иргэнд дэмжлэг, тусламж үзүүлэх тухай саналыг сумын Засаг даргад тавьж шийдвэрлүүлж байх.

#### 2. Зардлын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Цахилгааны техникийн нөхцөлийн төлбөрийг тогтмол зардлаас гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаал "Төсвийн захирагчийн төсөвт

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зохицуулалт хийх журам"-ын 3.1.6-д "Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх", Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн "Ангилал шинэчлэн батлах тухай" 211 дүгээр тушаалтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилтийг 760.3 мянган төгрөгөөр илүү, төсөвт байгууллагын өөрийн орлогын гүйцэтгэлийг 760.3 мянган төгрөгөөр дутуу тусгасан, үндсэн хөрөнгийн элэгдлийг 549,815.4 сая төгрөгөөр илүү илэрхийлснийг тус тус бууруулж залруулав.	1	551,336.0			1	551,336.0	1	551,336.0				
Дүн	1	551,336.0			1	551,336.0	1	551,336.0				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жаргалант сумын Засаг даргын үр дүнгийн урамшуулал 1,950.0 мянган төгрөгийг жилийн эцсийн тайландаа өглөгөөр бүртгээгүй, төсвийн жил дамнуулан олгосон байна.	1	1,950.0			1	1,950.0						
Байгууллагын бүтцэд батлагдаагүй орон тоонд 7,091.4 мянган төгрөгийн ажил хавсарсны нэмэгдэл цалин олгосон байна.	1	7,091.4			1	7,091.4						

Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх зардлаас 1,202.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.	1	1,202.5			1	1,202.5					
Багийн Засаг даргын нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 16 иргэнд 1,005.0 мянган төгрөгийн тэтгэмж дэмжлэг олгосон байна.	1	1,005.0					1	1,005.0			
Цахилгааны техникийн нөхцөлийн төлбөрийг тогтмол зардлаас гаргасан байна.	1	620.0					1	620.0			
Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 48,489.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	48,489.0			1	48,489.0					
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>60,357.9</b>			<b>4</b>	<b>58,732.9</b>	<b>2</b>	<b>1,625.0</b>			

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			